



Монголын  
Эмэгтэйчүүдийн  
сан



Иргэдийн  
Альяанс  
төв

---

# ЭМЭГТЭЙЧҮҮД СОНГУУЛЬД ХЭРХЭН ӨРСӨЛДӨЖ ЯЛАХ ВЭ?

---

Иргэдийн Альяанс төвөөс Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ийн конвенцыг хянах хөтөлбөрийн хүрээнд дахин эмхэтгэн гаргалаа.



## **ЭМЭГТЭЙЧҮҮД СОНГУУЛЬД ХЭРХЭН ӨРСӨЛДӨЖ ЯЛАХ ВЭ?**

*(Нэр дэвшигч эмэгтэйчүүдэд зориулсан  
гарын авлага)*

УЛААНБААТАР ХОТ  
2008он



Энэхүү гарын авлагыг хэвлүүлэхэд санхүүгийн туслалцаа үзүүлж иргэдэд хүргэх боломж олгосон Монголын Эмэгтэйчүүдийн Санд талархал илэрхийлье.

Орчуулсан: Д. Бямбадулам

Хянасан: Ж. Занаа

Хэвлэлд бэлтгэсэн: И. Баярмаа

## Өмнөх үг

Хүмүүнлэг ардчилсан нийгмийн сонгуулийн ерөнхий зарчим нь тэгш эрхийн зарчим буюу улс орны хөгжилд болон нийгмийн бүхий л хүрээнд хүйсийн тэгш оролцоо, төлөөллийг хангах явдал юм. Иймээс нийт хүн амын тал хувийг эзэлж буй эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд ч тал хувийг эзлэн оролцох нь тэдний иргэний болон улс төрийн эрхийг хангахаас гадна, Монголын ардчиллыг бэхжүүлэх, нийгмийн өмнө тулгамдсан чухал эмзэг асуудлуудыг оновчтой шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн бодит оролцоо хүчин чармайлт чухал ач холбогдолтой бөгөөд зайлшгүй шаардлагатай байна.

Энэхүү гарын авлага нь нэр дэвшигчдийн сонгуульд өрсөлдөх нөхцөл, арга барилыг энгийнээр оновчтой тайлбарлан үзүүлсэнээрээ онцлог бөгөөд Та бүхэнд бэлтгэн гаргаж байгааг гол зорилго нь:

- Иргэн бүрт хууль ёсоор олгогдсон эрхийн нэг болох улс төрийн эрх, түүний дотор сонгогдох эрхээ эдлэх боломжоо хэрэгжүүлэх;
- Мөн аливаа сонгуульд ажилд бэлтгэх, суралцахад тань туслах үүднээс толилуулж байгаа болно

Нэр дэвшигч эмэгтэйчүүддээ амжилт хүсье!  
Иргэдийн Альяанс төв

## Гарчиг

<b>1. Танилцуулга</b>	5
Яагаад сонгуульд өрсөлдөх болсон бэ?	6
Сонгуулийн ямар төрөлд өрсөлдөх вэ?	7
Хэн өрсөлдөж чадах вэ?	8
Нэр дэвшүүлэхэд ямар журамтай вэ?	9
Нэр дэвшигчийн үнэмлэхт юуг багтаах вэ?	10
<b>2. Таны үнэлгээнд тань</b>	11
Орчноо тодорхойлох нь	12
Өөрийгөө шалгах хуудас	15
<b>3. Явахад бэлэн ...</b>	19
Мөрийн хөтөлбөрөө боловсруулах нь	20
Өөрийн багаа бүрдүүлэх нь	22
Кампанит ажлын төлөвлөгөө	25
Кампанит ажлын төсвийг боловсруулах нь	26
<b>4. Яв давш зүтгэ</b>	28
Кампанит ажлын багаа дайчлах	29
Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах	33
Кампанит ажлын дуугаа зохиох	34
Сайн илтгэл бичээд түүнийгээ хүргэх нь	35
<b>5. Сонгуулийн өдөр</b>	36
Санал хураалтын байрууд, санал хураалт, сонгуулийн хэсгүүд	37
Албан ёсны ажиглагчид	38
<b>6. Сонгуулийн дараа</b>	41
Санхүүгийн тайлан гаргах	42
Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдсон өргөдөл гомдол гаргах нь	44
Нэр дэвшигчийн баримтлах 10 зарчим	46
<b>7. Таны мэдлэгт</b>	48

# 1

## ТАНИЛЦУУЛГА

Яагаад сонгуульд өрсөлдөх болсон бэ?  
Сонгуулийн ямар төрөлд өрсөлдөх вэ?  
Хэн өрсөлдөж чадах вэ?



Нэр дэвшүүлэхэд ямар жүрамтай вэ?  
Нэр дэвшигчийн үнэмлэхт юуг багтаах вэ?

## Яагаад сонгуульд өрсөлдөх болсон бэ?

Улс орноо удирдахад иргэн бүр оролцох эрхтэйг Үндсэн хуулиар, төрийн албанд зэрэг дэв дэвшихэд эрэгтэй, эмэгтэй хүн тэгш эрх адил нөхцөл боломж эдлэхийг Төрийн албаны хуулиар баталгаажуулсан хэдий ч энэхүү эрх бодитой хэрэгжихгүй байна.

Монгол Улсын Засгийн Газраас 1996 баталсан "Эмэгтэйчүүдийн Байдлыг Сайжруулах Үндэсний Хөтөлбөр"-ийн Ж-д: Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцох нөхцөл боломжийг өргөтгөх үндсэн дээр 2000 он гэхэд төр, засгийн төв, орон нутгийн сонгуульд ба томилолтын удирдах дээд албанд эмэгтэйчүүдийн төлөөллийг 20-иос доошгүй хувьд хүргэнэ гэж заасан байдаг.

2000 оны УИХ-ын сонгуулиар удирдах болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь төдийлэн ахиагүй ч дараа дараачийн сонгуульд улам илүү идэвхитэй оролцохыг Монгол Улсын нийгмийн өнөөгийн хөгжлийн байдал шаардаж байна.



Монголын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын Эвсэлээс удирдах болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүнд эмэгтэйчүүдийн улс төрийн идэвхи оролцоо дээшилж, нийгмийн сэтгэл зүйд нааштай өөрчлөлт гарч байна.

Эмэгтэйчүүд сонгуульд ялсаар ...

## Сонгуулийн ямар төрөлд оролцох вэ?






## Хэн өрсөлдөж чадах вэ?

Хэрэв Та...

- ✓ Монгол Улсын иргэн;
- ✓ Монгол хэлээр уншиж, бичиж чаддаг;
- ✓ Монгол Улсын засаг захиргааны нэгжид харьяалагдаж сонгогчоор бүртгэгдсэн;
- ✓ Харъялах засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэр дээр 1-ээс доошгүй жил оршин суусан;
- ✓ Эрхэлсэн ажилтай бол.



## Нэрээ дэвшүүлэхэд ямар журамтай вэ?

1. Сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга юмуу ажилтан бүртгэж үнэмлэхийг олгоно.
2. Хэрвээ сонгуульд өрсөлдөхөө болихыг хүсвэл сонгууль болох өдрөөс 3 хоногийн өмнө нэрээ дэвшүүлэхээр бүртгүүлсэн байгууллагадаа татгалзсан тухайгаа бичгээр мэдэгдэх ёстой.
3. Дараахи тохиолдолд Таны нэр дэвших эрхийг хасна:  
сонгогчдын саналд нөлөөлөхөөр мөнгө болон бэлэг өгсөн;
  - Алан хядлагын хэргийг үйлдсэн;
  - Зөвшөөрсөн хэмжээнээс илүү кампанит ажлын төсөв зарцуулсан;
  - Сонгуулийн хуулийг буруугаар ашигласан.
4. Та сонгуулийн өмнө нэр дэвшигчдийн албан ёсны жагсаалтаас хасагдсан бол Таны нэр дэвших эрх хасагдана.
5. Мөн хангалттай хэмжээний санал авч чадаагүй бол сонгуулийн дараа Таны нэр дэвшигчийн эрх хасагдана.



## **Санхүүгийн тайлан гаргах нь**

*Албан ёсны тайлан буюу тайлайнгийн агуулга хэлбэр*

- Өрсөлдөж байгаа албан тушаал;
- Өрсөлдөж байгаа албан тушаалд нэр дэвшигчийн мэргэжсэн байдлын талаар албан ёсны мэдээ;
- Аль улсын харьяат, иргэний харьялал, хаяг, төрсөн он, сар, өдөр;
- Шуудангийн хаяг;
- Ажил, мэргэжил;
- Монгол Улсын үндсэн хуулийг сахин биелүүлэх, хэрэгжүүлэх талаар амлаж байгаа албан ёсны мэдээллүүд;
- Бусад улсын харьяат иргэн биш, цагаач биш болохыг нотолсон мэдээ мэдээлэл;
- Үүрэг хариуцлагыг хүлээн авахад бэлэн байгаа талаархи амлалт;



- Нэр дэвшигчийн мэдлэг сайн гэдгийг нотолсон үнэмлэх, эрхийн бичиг, үнэн болохыг баталсан албан ёсны баримт, мэдээлэл.

# 2

## ТАНЫ ҮНЭЛГЭЭНД ТАНЬ...



Орчноо  
тодорхойлох нь

Өөрийгөө  
шалгах хуудас

## Орчноо тодорхойлох нь

### Энэ юу гэсэн утгатай вэ?

Орчноо тодорхойлно гэдэг бол Та үндсэндээ дараахи асуултуудад хариулахад хэрэглэх арга барил юм. Үүнд:

- ✓ Таны нөөц ямар /юу/ вэ?
- ✓ Хэн, юу Танд туслаж чадах вэ?
- ✓ Таны төлөвлөгөөнд юу саад болох вэ?

### Үүнийг яаж хийх вэ?

**1 шат.** Дараахи үндсэн баримт мэдээллийг олж авах


- ✓ Нийт хүн ам: Өрхийн тоо;
- ✓ Хүн амын хүйс боловсролын байдал, ажил эрхлэлт, шашин, шүтлэг гэх мэт үзүүлэлтүүд;
- ✓ Нийт сонгогчдын тоо буюу хамгийн сүүлийн сонгуульд оролцсон сонгогчдын тоо



Компанит ажил бүр хязгаарлагдмал эх үүсвэрийн нөөцтэй байдаг.

1. Цаг хугацаа
2. Мөнгө
3. Хүмүүс
4. Ур чадвар

- Компанит ажлын хамгийн хязгаарлагдмал зүйл нь цаг хугацаа юм.
- Ялахын тулд хэр хэмжээний мөнгө олох болон юунд зарцуулахыг компанит ажлын үед тооцоолсон байх ёстой. Сайн зарцуулсан мөнгө алдсан цаг хугацааг нөхөж, хүн хүчний болон ур чадварын дутагдалыг нөхөж чадна. Гэсэн хэдий ч маш бага мөнгө зарсан компанит ажил ч ялдаг.
- Хүмүүс ямар ч компанит ажлын хүчирхэг зэвсэг. Мөнгөний дутагдлыг нөхөх ганц эх үүсвэр нь хүмүүс юм.
- Компанит ажлын зорилгыг тодорхойлсноор ямар даалгаврыг ямар хүмүүс биелүүлж чадах вэ гэдгийг шийдэх нь чухал. (ЛЭОС-ийн гарын авлага, №1, 1999 он)



**2 шат. Өнгөрсөн сонгуулиудад хүн амын санал өгсөн байдлыг хэрхэн үнэлэх вэ?**

- Сонгогчид улс төрийн намуудаас нэр дэвшигчид эсвэл бие даан нэр дэвшигчдийн алинд нь санал өгсөн байна вэ?
- Тэд ямар намыг сонгосон байна вэ?
- Нэр дэвшигчдийн ямар шинж чанар тэднийг хамгийн илүү татаж чадсан бэ?
- Тэд өөрсдийн орон нутгийн хүмүүс улс төрийн бүлгүүдийн алиныг нь үнэнчээр дэмжсэн байна вэ?

**3 шат. Ямар бүлгүүд нь давамгайл байгааг нь тодорхойл.**

- Томоохон бүлгүүд;
- Төрийн болон төрийн бус байгууллагууд
- Сүм /шашны байгууллагууд/
- Бизнесийн байгууллагууд
- Үймээн дэгдээх зорилготой бүлгүүд
- Мэргэжлийн бүлгүүд /байгууллагууд
- Цэргийнхэн;
- Мөрийтэй тоглоомын газрын гишүүд
- Мансууруулах бодис наймаалагчид

#### 4 шат. Хэнийг нэрлэж болохыг таамаглаж тодорхойл.

- Хэн хамгийн илүү нөлөө, эрх мэдэлтэй вэ?
- Тэдний нөлөө эрх мэдлийн эх сурвалж юу вэ?
- Тэд нөлөө, эрх мэдлээ яаж ашиглаж байна вэ?
- Тэд Танд туслах уу? эсвэл саад болох уу?

#### 5 шат. Та өөрийн боломжоо тодорхойл.

- Бүх мэдээлэл Танд байгаа ч Таны ялах боломж ямар байна вэ?
- Таныг хамгийн их шүүмжлэгчид хэн байна вэ?
- Тэдний нөөц ямар байна вэ?
- Тэд ямар асуудлууд шийдвэрлэхээр өрсөлдөх вэ?
- Тэднийг хамгийн их дэмжиж болмоор /магадгүй/ ямар бүлгүүд байна вэ?
- Тэдний давуу тал хаанаа байна вэ?
- Тэдний сул тал хаанаа байна вэ?
- Улс төрийн намаас болон бие даан нэр дэвших хоёрын аль нь Танд илүү танд боломжтой байна вэ?

#### 6 шат. Орчноо тодорхойлсноор...

- Нийгмийн ярианууд;
- Албан бус ярилцлагууд



- Ажиглалт / сонсох, ажиглах дараа нь тэмдэглэл хийх/;
- Төв бүлгийн хэлэлцүүлгүүд;
- Орон нутгийн Сонгуулийн Хороодын мэдээнүүд;
- Иргэний Бүртгэлийн Албаны болон Орон нутгийн тоо бүртгэлийн Албаны мэдээнүүд.

## **Өөрийгөө шалгах хуудас**

Заавар: энэ нь нэр дэвшигчийн боломж буюу Та өөрийгөө танин мэдэхэд туслах зорилготой.

Асуулт болгонд үнэн зөв хариулна уу? Эхнээс нь дуустал асуултуудад харьцуулалт хий.

*Таны хэн болохыг хүмүүс мэддэг үү?*

Тийм Үгүй

Та тойргийн хүчтэй нөлөө бүхий хэсгүүдээс дэмжигчдийг татдаг уу?

Ажиллаж байгаа бүлгүүд, байгууллагууд болон хувь хүмүүс Таны хэн бэ?

Тэд Таныг хэлэлцдэг үү?

Таны улс төрийн намын дүр төрх Танд үндсэндээ нөлөөтэй юу?

Тойрогт Таны юу хийх гэж байгааг хүмүүс хүлээн зөвшөөрсөн үү?

*Өрсөлдөхөд Таны идэвхи, нөлөөлөл ямар байна вэ?*

1. Яагаад Та сонгуульд ажилд өрсөлдөхийг хүсдэг вэ?
2. Таны саналыг хэр зэрэг хүлээн зөвшөөрч дэмжиж байна вэ?
3. Сонгогчдын амьдралыг сайжруулахын тулд Та юу хийхийг хүсдэг вэ?
4. Та шийдвэрлэх ёстой ямар асуудлуудыг илүү мэдэрдэг вэ?
5. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэх талаар Та бусдад нөлөөлж чадах уу?





## **Та өөрийнхөө удирдлагын ур чадварын нийтлэг мэдрэмжээ тодорхойл**

### **Зөвшөөрнө Зөвшөөрөхгүй**


Та шийдвэр гаргах үедээ хэвлэл мэдээллийнхэнтэй холбоотой байдаг уу?

Танхимд, бүгдэд сонсогдохоор ярьж чаддаг уу?

Тойргийн удирдагчид бусдын арга барилын талаар Тантай ярилцахаар ирдэг.

Хүмүүс Таны гаргасан санал, шийдвэрийг хүлээн авч зөвшөөрдөг.





## **Та, Бүхнийг анхаарахад бэлэн үү?**

Тийм Үгүй

Таны боломжийг нурааж /үгүй хийж/ чадах тийм амьдралын нууц Танд байдаг уу?

Ямар ч үед Та үг хэлээ сайн ололцож чаддаг уу?

Та алиа хошин зантай юу?

Өөрийнхөө болон өөрийн амжилтуудын талаар сайн ярилцаж, тохиролцож чадах уу?

Хүмүүсийн бүх шинжүүдтэй санаа нийлж зохицож чадах уу?

Эрс тэс шүүмжлэлтэй үг хэлээ ололцож чадах уу?

Та хүчирхэг багийг эсэргүүцэх буюу өөртөө татаж чадах уу?

Та бүлгийг удирдаж чадах уу?

Та олон хүнтэй нүүр тулан санаа бодлоо илэрхийлж чадах уу?

Бага унтаж ихийг бүтээж чадах уу?

## Гэр бүл ба ажил

Тийм Үгүй

Таны завгүй төлөвлөлтөд гэр бүлийнхэн тань нүүр тулахад бэлэн үү?

Тэд эсэргүүцэл, шүүмжлэлүүдтэй учраа ололцож чадах уу?

Гэр бүлийнхэн чинь Таныг бүрэн дүүрэн дэмждэг үү?

Та ажил албаа орхихоор шийдсэн үү?

Өрсөлдөхөд эрүүл мэнд, сэтгэл зүй тань бэлэн үү?



# З

## **ЯВАХАД БЭЛЭН ...**

*Мөрийн хөтөлбөрөө боловсруулах нь*


Мөрийн хөтөлбөр гэж юу вэ?  
Мөрийн хөтөлбөрийн хэв загвар

*Өөрийнхөө багийг бүрдүүлэх нь*

Багийг хэн бүрдүүлэх вэ?  
Кампанит ажлын багийн гишүүдийн ажил үүрэг ямар байдаг вэ?

*Кампанит ажлын төсвөө боловсруулах нь*

Кампанит ажлын төсөв гэж юу вэ?  
Санхүүжилтийн эх үүсвэр болон зарцуулалтын талаар ямар зарчим байдаг вэ?  
Кампанит ажлын Төсөвийн хэв загвар.




## **Мөрийн хөтөлбөрөө боловсруулах нь**

Мөрийн хөтөлбөр гэж юу вэ?

Мөрийн хөтөлбөр бол нэр дэвшигчийг сонгуульд ялахаар төлөвлөсөн үйл ажиллагааны мэдэгдэл тайлан юм.

Сайн мөрийн хөтөлбөр нь:

- бодитой
- үнэмшилтэй
- ашиг тустай
- хүрч болохуйц
- шаардлагатай зайлшгүй
- хэмжиж болохуйц



Мөрийн хөтөлбөр нь нэр дэвшигчийн нийгэм эдийн засгийн болон улс төрийн, талаар шийдвэрлэх асуудлууд болон түүний албан тушаалыг тодорхойлон илэрхийлдэг.

## **Энэ бол мөрийн хөтөлбөрийн хэв загвар**

**Шийдвэрлэх асуудал:**

Эрүүл мэнд

**Стратеги зорилт:**

Эрүүл мэндийн  
халамж үйлчилгээг  
эмэгтэйчүүдэд хүргэх

**Хийгдэх үйл ажиллагаа:**

1. Бүгдэд эрүүл мэндийн халамжийг хүргэх боломж бий болгох
  - Эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээнд тодорхой хангалттай санхүүжилтыг батлах;
  - Эрүүлжүүлэх болон өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэлтийг онцлон анхаарах;
  - Ахмадуудад зориулсан халамжийн тогтолцоо болон уламжлалт анагаах ухааны тогтолцоо бий болгох;
  - Эмэгтэйчүүдийн үр ашигтай оролцоог нэмэгдүүлэх, энэ талаар хөтөлбөр гаргах;
2. Нөхөн үржихүйн эрүүл мэнд болон эрхүүд
  - Эх болон нярайн эндэгдлийг 50%-иар бууруулах;
  - Төрөөс нөхөн үржихүй болон гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрийг дэмжин санхүүжүүлэх. Эдгээр хөтөлбөрүүд нь хувь хүмүүст бэлгийн харьцааны зан үйл, үрэг хариуцлагыг ойлгуулах зорилготой боловсролыг багтаасан байна.
  - БЗХӨ-тэй тэмцэх жендэрийн хөтөлбөрийг боловсронгуй болгох.

*“1995 оны Бээжингийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” -өөс иш татав.*

## Сонгуульт ажлын багаа бүрдүүлэх нь



НЭР ДЭВШИГЧ

КАМПАНИЙН ЕРӨНХЙИ  
МЕНЕЖЕР



Үйлчилгээний  
ажилтан

Санхүүгийн  
ажилиан

Хууль зүй,  
судалгааны  
ажилтан

Олон нийттэй  
харьцах  
мэдээллийн  
ажилтан

Зохицуулагч нар

## Кампанит ажлын Багийн гишүүдийн гүйцэтгэх үйл ажиллагаанууд

### Кампанит ажлын Ерөнхий Менежер

- Төлөвлөлт, хяналт, хяналт шинжлэгээнүүд болон нэр дэвшигчийн кампанит ажлын үнэлгээг хийдэг;
- Нэр дэвшигчийн болон түүний улс төрийн байгууллагын эрхийг хамгаалах;
- Санал асуулга болон судалгааны асуудлыг нарийвчлан төлөвлөнө.

### Санхүүгийн ажилтан

- Кампанит ажлын төсвийг боловсруулах;
- Санхүүжилтийн эх үүсвэрийг олж авах;
- Санхүүжилтийг зарцуулах;
- Кампанит ажлын санхүүгийн байдлыг хянаж шинжлэх;
- Мөнгөний урсгалыг хянаж шинжлэх;
- Санхүүгийн тайланг гаргах.



### Олон нийтийн харилцаа/ Мэдээллийн харилцаа

- Нэр дэвшигчийн нийгмийн /олон нийтийн/ төслийг зохиох ерөнхий төлөвлөгөөг боловсруулах;
- Орж гарч байгаа харилцааны урсгалд хяналт хийх;
- Дэмжлэгийн урамшууллууд, зурагт хуудсууд, бусад туслах материалуудыг бэлтгэх, хуваарилалтыг хянах;
- Айлчлагчид, зочид буудал болон бусад нэр дэвшигчидтэй уулзах, ярих буюу бусад хүмүүст үйлчлэх, зохион байгуулах.



### **Хууль зүй/ судалгааны ажилтан**



- Сонгогчдын бүртгэлийн судалгааны загварыг боловсруулж, судалгаа хийх;
- Кампанит ажлын стратеги, намын мөрийн хөтөлбөр, илтгэл, хэлэх үгийг бэлтгэн боловсруулахад хэрэгтэй мэдээллийг цуглуулах техник болон хэрэгжүүлэх арга барилыг бодож боловсруулах;
- Хууль зүйн асуудлаар нэр дэвшигчид зөвлөх үүрэгтэй.

### **Үйлчилгээний ажилтан**

- Кампанит ажлын хөтөлбөрүүдийг шууд хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **Сайн дурын ажилтан, дэмжигч**

- Ямар ч улс төрийн кампанит ажлын хувьд сайн дурынхны хүч, оролцоо хамгийн чухал хөдөлгөгч хүч, гол хөшүүрэг нь болдог.



## Кампанит ажлын Төлөвлөгөө

Кампанит ажлын төлөвлөгөө нь ажлыг зохион байгуулах ерөнхий төсөөллийг бий болгодог. Энэ нь кампанийн үйл ажиллагааг зохион байгуулах, нэн тэргүүний ажлыг тодорхойлох, нөөц бололцоог илрүүлэх зэвсэг болно. Кампанит ажлын төлөвлөгөө нь гарч буй ахиц дэвшлийг хэмжих сайн хэмжүүр бөгөөд боловсронгуй төлөвлөгөө боловсруулан түүний дагуу ажиллавал кампанит ажил гол зорилгоосоо хазаахгүй болно. Кампанит ажлын боловсронгуй төлөвлөгөө нь дараахи үндсэн зургаан үндсэн шинж чанарыг агуулах ёстой:

1. Улс төрийн орчны үнэлгээ болон чиглэл
2. Кампанит ажлын стратеги
3. Арга техник
4. Цаг хугацааны хэмжүүр
5. Менежментийн бүтэц
6. Төсөв

## Кампанит ажлын Төсөвийг боловсруулах нь

Зарлагуудын хэв загвар бол:

Зарлагын төрөл

Үнэ өртөг

1. Материалууд  
Гэрэл зураг /камер/  
Дугтуй  
Шуудангийн зардал  
Албан газрын хангамжууд
2. Сонгогчдын бүртгэлийн болон бусад судалгаанууд  
Судлаачдын хөлс  
Судалгааны зардал
3. Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа  
Цаас  
Хэвлэлийн өртөг  
ТВ сурталчилгааны үнэ
4. Хуваарилалт
5. Бусад зардлууд



Нийт дүн

## **Санхүүжилтийн эх үүсвэрүүд болон зарцуулалтын талаар ямар зарчим байдаг вэ?**

Зарцуулалтын болон хандив тусламжийн талаар албан ёсоор мэдээлэл хийхийг мартаж болохгүй...

Зарцуулалт, хандив тусламжийн албан ёсны мэдээлэл нь бүх зардал болон хандив тусламжийн албан ёсны нарийвчлан тодорхойлсон үнэн зөв, тодорхой мэдээлэл байдаг. Энэ нь сонгууль болсноос хойш 30 өдөрт багтаан, нэр дэвшүүлэх үнэмлэхийг тань бүртгэсэн сонгуулийн хорооны ажилтанд тайлагнасан байна.

## **Ямар хандивыг хориглодог вэ?**

Кампанит ажлын үе эхэлснээс сонгуулийн өдөр хүртэлх хугацаанд зам засварлах, сургуулийн байр, гүүр, эрүүл мэндийн төвүүд, эмнэлгүүд, сүм дуган болон явган хүний зам зэрэг олон нийтийн хэрэгцээний барилга байгууламж барихаар зориулсан хандив, тусламжуудыг:

- Нэр дэвшигчийн эхнэр буюу нөхөр;
- Нэр дэвшигчийн ямар нэгэн хамаатан садан /цусан төрлийн садан төрөл/;
- Нэр дэвшигчийн кампанит ажлын менежер, төлөөлөгч, төлөөллийн газарт бэлэглэхийг хориглоно.

## Санхүүгийн хориглосон ямар хэлбэрийн эх үүсвэрүүд байдаг вэ?

Дараах аргаар санхүүгийн эх үүсвэр олохыг хориглоно.

- Диско бүжиг;
- Лотто тоглоомууд;
- Буудлагын тоглоомууд;
- Боксын тэмцээн, тоглолт;
- Бинго тоглоомууд;
- Гоо бүсгүйн уралдаан тэмцээнүүд;
- Үзвэрүүд, урлагийн тоглолтууд болон бусад адил төстэй үйл ажиллагаанууд.



Мөн санхүүжүүлэлтийн үйл ажиллагаануудыг сонгууль явагдах үеэс сонгуулийн өдөр хүртэл хүлээн зөвшөөрөхгүй /хориглоно/.

Нэр дэвшигчийн кампанит ажлын менежер, эсвэл түүний төлөөлөгч болон тэдний өмнөөс ямар нэг хувь хүн сонгуулийн үр дүнд нөлөөлөх зорилгоор шууд ба шууд бусаар дэмжиж туслах тээврийн хөлс, хоол унд буюу үнэ бүхий эд зүйлсийг дараах тохиолдлуудад:

- Их хурал, чуулганы өдрөөр;
- Ямар нэг албан ёсны төрийн чуулга уулзалтын үеээр;
- Бүртгэлийн өдрөөр;
- Сонгуулийн өдрөөр ямар нэг нэр дэвшигчээс төрийн (олон нийтийн) албан хаагч, ажилтанд өгөх буюу үүлээн авах нь хууль бус болно.



## Яв, Давш, Зүтгээ

Кампанит ажлын багаа дайчлах нь


Сонгочдын тоолох хуудас  
Миний кампанит ажлын өдрүүд хамгаас чухал.

Кампанит ажлын амжилтаа үнэлэх нь

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг ашиглах нь

Кампанит ажлын дуугаа зохиох нь

Маш сайн илтгэл бичээд түүнийгээ хүргэх нь




## Кампанит ажлын багаа дайчлах нь

Сонгуулийн кампанийн багийн бүрэлдэхүүнд кампанийн менежер болон доорхи гол албан тушаалтанууд ордог.

### Кампанийн менежер

- Сонгуулийн штабын удирдлага болон зөвлөхүүдийн ажлыг бүх түвшинд удирдан зохион байгуулна;
- Зохион байгуулалтын бүдүүвчийг гаргаж хэн нь хэний удирдлага дор ажиллаж, хэнд тайлагнаж, илтгэж байхыг ил тод байлгана;
- Сонгуулийн кампанийн явцыг байнга хянаж, түүний явцад гарч буй өөрчлөлтүүдийг нийт төлөвлөгөөнд тусгаж ажиллана.




### Зохицуулагч

- Өрх бүрт кампанит ажлыг зохион байгуулах;
- Сонгуулийн штабын байрны ажиллах нөхцлийг бүрдүүлнэ;
- Ажлын явцыг хянаж, ололт амжилт, алдаа дутагдлын талаар долоо хоног тутам менежерт тайлагнана.



## Сонгогчдыг тодорхойлох 1бүртгэх1 хуудас

1. Зохицуулагч нь Таныг дэмжигчид, Таны өрсөлдөгчийн дэмжигчид болон үл дэмжигчдийг тодорхойлно. Үл дэмжигчдийг Таны талд элсүүлэх, Таны өрсөлдөгчдийн дэмжигчдийг төвийг сахиулах ёстой.
2. Зохицуулагч нар долоо хоног бүр Сонгогчдыг тодорхойлох хуудсыг ажиллуулна.
3. Санал өгөх байдлыг тодорхойлох хуудас...
  - Гэр бүлийн гишүүд болон тэдний сонгууль өгөх гишүүдийн нэрс
  - Тэдний ямар сонголт хийхийг тогтоох \заах, үзүүлэх\
4. Сонгогчдыг тодорхойлох Хуудас нь Сонгуулийн Ерөнхий Менежерээс хүчээ хувиарлах, хүчтэй хэсэг дэх дэмжлэгийн түншээ солин, сул хэсэгтээ нөөцөө төвлөрүүлэхэд тусална.



### **Сонгогчдыг Тодорхойлох Хуудас**

Явсан хэсэг: \_\_\_\_\_

Гэр бүлийн гишүүдийн нэрс	Сонгуулийн насанд хүрсэн гишүүд	Илүү гэж үзэж байгаа сонголт





## Миний кампанит ажлын өдрүүд маш чухал

ҮЙЛ АЖИЛЛАГАА	ӨДРҮҮД										ГАРАХ ҮР ДҮН/ ГАРЦ	ХАРИУЦСАН ХЭСЭГ
	1	2	3	4	5	6	7	8	9	10		
1. Кампанит ажлын багаа бүрдүүлэх											Кампанит ажлын багийн хүмүүс	
2. Кампанит ажлын төсвөө боловсруулах											Кампанит ажлын төсөв	
3. Ерөнхий санхүүжилт											Санхүүжилт	
4. Кампанит ажлын багаа дайчлах, айл өрх бүрээр явах, Сонгогчдыг тодорхойлох хуудас бэлтгэх											Сонгогчдыг тодорхойлох хуудас, Өрхийн тоо	
5. Кампанит ажил											Ухуулах болон зурагт хуудсууд	
6. Цуглаанд оролцох											Элсүүлсэн сонгогчид	



## **Кампанит ажлын амжилтаа үнэлэх нь**

Кампанит ажлын амжилтын үнэлэлтийг дүүргийн түвшинд 3-аас доошгүй өдөрт, мужууд, аймаг- хотын түвшинд долоо хоногт 1-ээс доошгүй удаа хийгдсэн байна. Энэ нь доорхи хүснэгтийн хэлбэрээр хийгдэнэ.

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТӨЛӨВЛӨГӨӨ ЗОРИЛГО	ОДООГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН БАЙДАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ- НИЙ ТОВЧЛОЛ	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛД ХАНДАХ АРГА ХЭЛБЭРҮҮД
1.Очсон ерхийн тоо				
2.Цуглуулсан санхүүжилт				
3.Тараасан ухуулах хуудсууд				
4.Наасан зурагт хуудсууд				

## **Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах нь**

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахдаа,

- Кампанит ажлынхаа мэдээлэл буюу сэдвийг тогтоох;
- Та хүсэж бодож байгаа дүр төрхөө тодруулах;

Оюун бол


*Шударга  
Ухаантай  
Шилдэг  
Жавхаатай  
Залуу*

- Төсөв дотроо заасан хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах;
- Одоогоор хамгийн сайн, сонголт их мэдээллийн хэрэгслийг ашиглах:  
a/ улс төрийн зарлал буюу товхимол;  
b/ тээврийн хэрэгсэл дээр зурагт хуудсууд наах;



- с/ Дугуй \З дугуй\, хөнгөн тэрэг, автобусаар сурталчилах зэрэг.
- Хүмүүс Таныг таньж тогтоох өнгийг онцлон ашиглах.

Хэвлэл тухайн нэр дэвшигчийн өөрөө өөрийгөө төсөөлж байгаа төсөөллөөс үл хамааралтай имиджийг түүнд бий болгож өгдөг. Имидж бол нэр дэвшигчийн гадаад байдлын ааш, маяг дохио зангаа, үйл байдлын стиль, итгэл үнэмшил, хувийн шинж чанар, мэргэжлийн чадвар, түүнчлэн үзэл бодлоо сонгогчдод хүргэж байгаа байдал, хувийн амьдралын цогц юм. Нэр дэвшигчийн имиджийг 100 хувь гэж үзвэл, түүний ярьж буй зүйлийн агуулга-7, дуу хоолой -38, гадаад байдал-55, хувийг тус тус бүрдүүлдэг гэсэн судалгаа байдаг.



### ***Кампанит ажлын дуугаа зохиох нь***

Эдгээр хялбар алхмуудыг мөрд...

- Олонд тархаж байгаа дуугаар кампанит ажлын дууг хийх;
- Сайн мэдэх дууны эх үгийн үеийг адил үетэй шүлгээр солих;
- Шүлгээ ойлгогдохоор буюу сүүл холбон зохиох;
- Олон нийтэд өрсөлдөгчөө муулсан дууг хэрэглэхээс зайлсхийх;
- Танай амжилт болон мөрийн хөтөлбөрийн талаар ярилцах буюу дуулах болно.

## **Сайн илтгэл бичиж түүнийгээ яаж хүмүүст хүргэх вэ?**

### Агуулга:

- Сонгогчид харилцан ярилцаж чадах асуудлуудыг шийдвэрлэх талаар ярилцах;
- Тодорхой бодитой шийдвэрүүдийг санал болгох;

### Зорилтууд:

- Хэрэв сонгогчдын мэдлэг хязгаарлагдмал – Мэдээлэх;
- Хэрэв сонгогчид үндсэндээ Таны сонгуульд албан тушаалд өрсөлдөхийг хүлээн зөвшөөрч байгаа – Итгүүлэх;
- Хэрэв сонгогчид Таны сонгуульд албан тушаалд өрсөлдөхийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа – Ухуулах;

### Илтгэхдээ:

- Өөрийг тань танилцуулсан хүнд талархалаа илэрхийлэх;
- Сонгогчдод алдар хүндтэй хүмүүсээр мэндчилгээ дэвшүүлэх;
- Сонгогчдод хүндэтгэлээ шууд илэрхийлэх;
- Яагаад өрсөлдөж байгаагаа дурьдаж сануулах болон энэ тухай энгийн товчлолыг өгөх;
- Мэдээллээ товч бөгөөд тодорхой тайлбарлах;
- Дэс дараалалтай, сайн зохион байгуулах;
- Илтгэлээ сонирхолтой болгохын тулд нэмэлт хошигнол юм уу өөрийнхөө тухай богино түүхү
- Сонгогчдоо байнга ажиглах;
- Дохио зангаа хэрэглэх;
- Илтгэлээ төгсгөхдөө санаагаа товч дүгнэж, сонгогчдыг үйл ажиллагаанд уриалах;
- Ярьж байх үед баруун дээш нүдний харц чиглэсэн байх нь сонгогчдод итгэл төрүүлдэг.



# 5

## Сонгуулийн өдөр...

Санал авах байрууд,  
Албан ёсны санал хураалт,  
Сонгуулийн хэсгүүд,  
Албан ёсны ажиглагчид.



## **Санал хураалтын байрууд, Албан ёсны санал хураалт ба Сонгуулийн хэсэг**

### **Санал авах байр**

Санал авах байрыг ээлжит сонгууль явагдахын өмнө Сонгуулийн Хорооноос зөвшөөрсөн буюу баталсаны дагуу зохион байгуулсан байна.

### **Сонгуулийн хэсгийг байгуулах**

- Дүүрэг бүр нэгээс доошгүй сонгуулийн хэсэгтэй байна.
- Сонгуулийн Хорооноос өөрчлөн тогтоогоогүй бол өмнөх сонгууль явагдсан тоотой адил батласнаар дүүрэг болгонд сонгуулийн хэсгийг байгуулна.

### **Албан ёсны саналын хуудас**

Албан ёсны саналын хуудас нь:

- Гагцхүү Засгийн газрын Хэвлэх газрын буюу Сонгуулийн Ерөнхий Хороогоор шалгагдсан Хэвлэх газрын тоног төхөөрөмжүүдээр хэвлэсэн байна.
- "№001" -ээс эхлэн дугаарласан байна.
- Сонгогч болгонд нэг буюу тавны нэг хувиар тараасан байна.
- *Монгол хэлээр бичсэн байна.*

## Сонгуулийн албан ёсны Ажиглагчид

### Нэр дэвшигчдийн албан ёсны Ажиглагчид

Санал хураалтын байр буюу санал хураах төвд нэр дэвшигч бүр 2 ажиглагчийг томилон ээлжлэн ажиллуулна.

### Ажиглагчдийн мэргэшил, ур чадвар

- Мэргэшсэн\бэлтгэгдсэн\сонгогч;
- Нэр хүндтэй;
- Монгол хэлээр бичиж уншиж ойлгодог;
- Санал авах байранд Сонгуулийн хорооны гишүүн буюу даргатай садан төрлийн хамаатан биш ажиглагч томилогдох ёстой;
- Ямар нэгэн сонгуультай холбоотой хэрэг зөрчил болон бусад гэмт хэргээр ял эдэлж байгаагүй.



### Ажиглагчийн эрх. үүрэг

- Санал авах байранд урьдчилан зассан \зохион байгуулсан\ зайнд байрлана;
- Сонгуулийн хорооны ажиллагааг мэдээлэх буюу хянах;
- Харж ажигласнаа тэмдэглэх;
- Санал хураалтын тооллогын явц, санал хураалтын дүн \сонгуулийн дүн\, саналын хуудас болон санал авах хайрцаг зэрэг сонгуулийн ажиллагааны талаархи гэрэл зураг авах;
- Сонгуулийн хорооны даргыг зарласны дараа тэд санал хураалтын дүнг мэдээлэх;
- Сонгуулийн дүнгийн мэдээлэл нь Сонгуулийн хорооны гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр гэж үзнэ. Сонгуулийн хорооны гишүүд гарын үсэг зурж гүйцсэний дараагаар тэд сонгуулийн дүнг зарлан мэдэгдэнэ. Ажиглагч нь сонгуулийн эдгээр баримт бичгийг хөндөх эрхгүй бөгөөд санал хураалтын үйл явцад саад болохыг хориглоно;
- Тэд ямар нэг хууль бус ба хуулийг зөрчсөн хэрэг гарсан гэж






үзвэл Сонгуулийн Хорооны гишүүдэд өргөдөл гомдлоо гаргана;

- Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдсон өргөдөл, гомдол гаргах болон сонгуулийн хэсгийн Хороогоор шийдвэрлүүлэх эрхтэй;
- Нэр дэвшигч бүрийн авсан тоог мэдээлсэн албан ёсны бичиг хүсэх эрхтэй. Энэ баримт бичиг нь Сонгуулийн Хорооны гишүүд болон Дарга нар гарын үсэг зурж, тамга даран ёсчилсон байх ёстой.




# 6

## **Сонгуулийн дараа...**



## Санхүүгийн тайлан гаргах нь

Албан ёсны тайлан буюу тайлангийн агуулга,  
хэлбэр нь:



Хандив тусламж зарцуулалтын албан ёсны мэдээ нь бичгээр, тусламж дэмжлэгийг хүлээн авсан тухай баримт, нэр дэвшигчийн зөвшөөрсөн буюу амласан зэрэг бусад баримт бичгүүдэд дараахи зүйлүүдийг тодорхой багтаасан байна. Үүнд:

- Хандив тусламж бүрийн нийлбэр дүн, хүлээн авсан он, сар өдөр, хандив тусламжийг хүлээн авсан хүний нэр, тодорхой хаяг;
- Зарцуулалт бүрийн нийлбэр дүн, хүлээн авсан он, сар өдөр зарцуулалтын буюу төлбөр болгоныг хийсэн хүний бүтэн нэр, тодорхой хаяг;
- Ямар нэг төлөгдөөгүй өр төлбөр, энэхүү төлөгдөөгүй төлбөрийн нийлбэр дүн, төрөл, хэлбэр;
- Хэрэв нэр дэвшигч хандив тусламж аваагүй, зарцуулаагүй болон хүлээсэн (зайлшгүй) ажил үүрэгтэй байсан бол тийм баримт бичгийг албан мэдээнд тусгасан байна.


**Орлогын тайлан-мэдээ болон зарцуулалтын тайлан мэдээ дараах хэлбэртэй байж болно.**

Он сар өдөр .....

Нэр .....

Хаяг .....

Нийлбэр дүн .....



## **Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдсон өргөдөл, гомдол аргах нь**

Сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон болон сонгуулийн хэсгийн хорооны шийдвэрийн талаар зохих дээд шатны сонгуулийн хороонд өргөдөл гомдол гаргаж болно. Сонгуулийн хороо өргөдөл, гомдлыг шийдвэрлэх буюу, холбогдох байгууллагад уламжлах бүрэн эхртэй.



## Эмэгтэйчүүд УИХ-ын болон орон нутгийн сонгуульд өрсөлдөхийг хүсч байна.


### Эмэгтэйчүүдийн давуу тал:

- Ажилдаа хариуцлагатай, бусдын төлөө санаа тавьдаг, шударга
- Авилгал болон нийгмийн бусад бусармаг үйлдэлд оролцдоггүй
- Нийгмийн эмзэг асуудалд анхааралтай ханддаг, хүмүүнлэг
- Ил тод, нээлттэй байдлыг бий болгоно

Эмэгтэйчүүд улс төрд оролцсоноор улс орон алддаггүйн жишээг ардчилал хөгжсөн өндөр хөгжилтэй орнуудын туршлага харуулж байна. Жишээ нь: Норвеги, Швед зэрэг Скандинавын орнуудын парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл шийдвэрт нөлөөлөхүйц хэмжээнд байдаг учраас тэдгээр оронд нийгмийн асуудал бүрэн шийдэгдэж боловсролыг үнэ төлбөргүй эзэмшүүлдэг, эмэгтэйчүүд хүүхдийн эрх ашиг, хүний эрх зэрэг нийгмийн амин чухал асуудлуудыг нааштай шийдвэрлэж чаджээ. Өнөөдөр манай улс оронд бий болоод байгаа олон эмзэг асуудал, тухайлбал эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн хүмүүжилтэй холбоотой асуудлыг зүй зохистойгоор шийдвэрлэх, мөн ажилгүйдэл, ядуурал, архидалт, хүчирхийллийг таслан зогсоох, эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарласан хууль тогтоомжид өөрчлөлт оруулахад эмэгтэйчүүдийн бодит оролцоо, хүчин чармайлт зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд үүнийг ч нийгэм шаардаж байгаа билээ.



**Удирдах болон шийдвэр гаргах түвшинд  
ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн  
баримтлах 10 зарчим**



1. Төрийн алба бол олон нийтийн итгэл;  
Иргэдийн аюулгүй байдалд сайн үйлчлэх  
Гол нь нийцтэй бөгөөд соргог бай
2. Холыг харж удирдах;  
Зорилготой байж, холыг харах  
Хүмүүсийн хүсэл зоригийн дагуу шинэ юмыг эхлэх
3. Хүмүүсийг ойлгож тэдэнтэй санал нэг байх;  
Хүмүүсийн талаар мэдээлэл цуглуулж, тэдний шаардлагыг мэдрэх  
Тэдний ялалтанд нь баярлаж, тэдний зовлонг хуваалцах
4. Үүнээс мэдэж нөхцөл байдлаа тодорхойлох;  
Танд өгсөн мэдээлэлд үнэлгээ хийх  
Сайтар судалж байж алхмаа хий  
Шүүмжлэж байж бүтээ \зохион байгуул\  
Үйл ажиллагааны эхний үеийг мэдэх  
Үйл ажиллагааг ойлголцлоор удирдах ёстой.

5. Үйл ажиллагаагаа өмнө нь төлөвлөж уян хатан бай;  
Тохиолдож болзошгүй зүйлийг урьдчилан харж, үүндээ бэлтгэсэн байх  
Нөхцөл байдлыг шаардлагатай бол өөрчил
6. Хүмүүст эрх мэдэл олгох;  
Тэднийг бие даалгаж сурга, дайчил, мөн хэрэгжүүл  
Тэдний бүх чадавхийг өөрсдөөр нь хөгжүүл
7. Аливаа юмыг зөв замаар нь хий;  
Та ямар ч юмнаас хамгийн бага зардлаар ашиг гаргах ёстой  
Үр ашигтай, бүтээмжтэй, эдийн засгийг хэрэгжүүлэх
8. Шаардлагатай үед хаана ч хүрэх;  
Та ажил хэрэгт яг одоогийнх шигээ холбоо харилцаатай байх ёстой  
Сонсож байж шийдэх, ярилцаж байж тушаа
9. Хэнтэй ч шударга ил тод бай;  
Найзууд, дайснуудтай хэлэлцэн тохиролцож адилхан үүрэг даалгавар өг  
Ямар нэг юм хийхэд шагнахгүйгээр найдаж сур  
Яах ч аргагүй үед зэмлэж сур
10. Зогс харж байж нүү \хий\.  
Хянаж шинжил, үнэлж дүгнэж боловсруул  
Өчигдөр муу байсан юм өнөөдөр сайн болж мэднэ  
Өнөөдөр сайн байсан юм маргааш муу болж мэднэ







## **ТАНЫ МЭДЛЭГТ...**

УИХ-ын сонгуульд НЭР ДЭВШИГЧ ТА сонгогчдын эрхийг баталгаажуулахын төлөө ажиллаж чадна гэж өөрийгөө үзэж байгаа бол доорхи асуултанд хариулт бичээрэй.

- ◆ Эмэгтэйчүүдийн тэгш эрх, жендерийн тэгш эрхийг зөрчдөг хууль тогтоомжуудыг Та мэдэх үү?
- ◆ 1994 онд батлагдсан тэтгэвэр тэтгэмжийн хуулийн дагуу олон хүүхэд төрүүлсэн гэдэг шалтгаанаар хөдөлмөрийн чадвартай хирнээ тэтгэвэрт эрт гарсан эмэгтэйчүүдийг асуудлыг Та хэрхэн үздэг?
- ◆ Та Их хурлын гишүүн болбол эдгээр асуудлыг хэрхэн шийдэх вэ? Тэдний амьдрал, ажил эрхлэх баталгааг бүрдүүлэх ямар хууль гаргаж, тодорхой арга хэмжээ авах вэ?
- ◆ Дуртай ажил, мэргэжлээрээ ажиллах боломж эмэгтэйчүүдийн хувьд хангалтгүй байна. Үүнийг шийдэхийн тулд ямар хуулийг шинээр гаргах, ямар хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж Та үзэж байна?
- ◆ Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг яаж шийдэх вэ? Тэднийг садар самуны бизнест ашиглах, худалдах зэрэг асуудлыг яаж шийдэх вэ?
- ◆ Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр эмэгтэйчүүдийг гутаан доромжлох байдлыг хэрхэн таслан зогсоох вэ?

- ◆ Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаархи олон улсын хууль, эрх зүйн баримт бичиг, үндэсний хуулиудын талаар Та юу мэдэх вэ?
- ◆ Тэдгээр нь хүний эрхийн ямар зарчмуудыг мөрдлөг болгодог вэ? Тэдгээр зарчмаас ямыг нь Та үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх вэ?
- ◆ Эмэгтэйчүүдийг улс төр, нийгмийн амьдралд өргөн оролцуулах нь нийгэмд ямар ашигтай гэж Та үздэг вэ?
- ◆ Эрэгтэйчүүдийн боловсрол, мэдлэг, хүмүүжлийн доголдлыг арилгах ямар арга зам байна гэж Та үзэж байна? Архидалтай яаж тэмцэх вэ?
- ◆ Гэр бүл, нийгмийн хүрээнд жендерийн мэдрэмжийг сайжруулах зорилгоор юу хийх шаардлагатай гэж Та үздэг вэ?
- ◆ Эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарласан ёс заншил, хууль тогтоомжинд өөрчлөлт оруулахын тулд Та юу хийх вэ?
- ◆ Жижиг дунд бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх боломжийг хангахад төрөөс ямар нэмэлт арга хэмжээ авах, хууль тогтоомж гаргах, боловсронгуй болгох шаардлагатай гэж Та үзэж байна?
- ◆ Эмэгтэйчүүдэд зээл олгох нь яагаад хомс байдаг вэ?
- ◆ Жендер ба жендерийн тэгш эрхийн талаар таны ойлголт ямар хэмжээнд байна гэж Та үздэг вэ? Энэ талын сургалтанд хамрагдаж байсан уу? Та УИХ-ын гишүүн болбол жендерийн тэгш эрхийн асуудлаар бусаддаа нөлөөлж ажиллаж чадах уу?
- ◆ Танай намын мөрийн хөтөлбөр болон сонгогчидтой хийсэн гэрээнд жендерийн тэгш эрхийн талаар хэрхэн тусгасныг танилцуулна уу?

## **Ашигласан материал**

- Филиппин улсын Хууль зүйн хөгжлийн төвийн “Орон нутгийн сонгуульд хэрхэн өрсөлдөж ялах вэ?” гарын авлага;
- Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн “Сонгуулийн кампани” гарын авлага;
- Монголын Эмэгтэйчүүдийн Төрийн Бус Байгууллагуудын эвслээс 2000 оны УИХ-ын сонгуульд зориулж хэрэгжүүлсэн “Сонгогчдын боловсрол-2000” сонины төслийн материал.
- Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн “Эмэгтэйчүүдийн манлайлал” гарын авлага, 1999 он



BEST COLOR INTERNATIONAL  
"BCI" Хэвлэлийн компани  
Утас: 319032